

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА, ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН 2009 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН
ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

**3.1. Эрхлэх асуудлын хүрээнд төсвийн Ерөнхийлөн
захирагчаас аймаг, нийслэлийн Засаг даргатай
байгуулсан гэрээний үүргийн биелэлт**

Дорноговь аймгийн Засаг дарга П.Ганхуяг төсвийн Ерөнхийлөн захирагч /сайд/ нартай байгуулсан гэрээний үүргийн биелэлтийг тус тусын Яамдад 2010 оны эхэнд гаргаж хүргүүлсэн байна.

Аймгийн Засаг дарга нийт 9 төсвийн Ерөнхийлөн захирагчтай гэрээ байгуулж, гэрээний үүргээ 93,3 хувиар биелүүлж, үнэлгээний оноо 4,66 байна. /Наймдугаар хавсралт/

Харьцангуй бага хувийн биелэлттэй байгаа зарим үүргийн талаар тайлбар хийхэд:

1. Монгол улсын шадар сайдтай байгуулсан гэрээнд: Хэмжих хэрэгслийн баталгаажуулалт хийх зорилт 85,0 хувьтай гэсэн нь:

Хэмжлийн эталон төхөөрөмж хэрэглэх зорилт хөрөнгийн боломжгүйгээс шийдвэрлэгдээгүй. Үүнд: усны тоолуурын тохируулгын эталон тоног төхөөрөмж, хүнсний бүтээгдэхүүний хүнд элемент болон хорыг тодорхойлох лабораторийн тоног төхөөрөмж авах нэн шаардлагатай байгаа. Төсөл боловсруулж холбогдох байгууллагуудад санал хүргүүлсэн боловч шийдвэрлэгдээгүй байна. Одоо байгаа тоног төхөөрөмж, техникээ ашиглаж, үйл ажиллагааны зорилтоо 85,0 хувиар биелүүлсэн байна.

2. ХХААЖДҮ-ийн сайдтай байгуулсан гэрээнд: Хүнсний бүтээгдэхүүний хангамж, чанар, аюулгүй байдлыг хангах талаар зохиосон ажил 74,0 хувьтай гэсэн нь:

Стандартчилал, хэмжил зүйн хэлтэс болон аймгийн Мэргэжлийн хяналтын газраас хийсэн үзлэг, шалгалтуудын дундаж хувиар энэ үнэлгээг гаргажээ. Тухайлбал, аймгийн МХГ-аас аймгийн төвийн хүнсний худалдаа эрхлэж буй 268 цэгт хяналт шалгалт хийхэд 85% нь ажлын байрны эрүүл ахуйн шаардлага хангасан, 95% нь хүнсний бүтээгдэхүүний хадгалалтын горим, чанар аюулгүй байдал, хүнсний сав баглаа боодол, шошгоны стандарт шаардлага хангасан байна. Хоол үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй 110 цэгт хяналт шалгалт хийхэд 77% нь батлагдсан жор технологийн дагуу дотоодын хяналт шалгалтын тогтолцоо нэвтрүүлсэн, 85% нь үйлдвэрлэлийн болон үйлчилгээний зориулалтын тоног төхөөрөмжтэй, хадгалах нөхцлийн эрүүл ахуйн шаардлага хангасан, 80% нь ажлын байрны цэвэрлэгээ, гэрэлтүүлэг, тоног төхөөрөмж, сав багаж хэрэгслийн угаалга ариутгал халдваргүйтлийг зохих журмын дагуу хийж гүйцэтгэсэн байна. Хүнсний үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа 15 цэгт хяналт шалгалт явуулахад 87.5% нь бүтээгдэхүүнийг бэлтгэж боловсруулах технологи, урсгал зөв хийгдэж, 93.8 % нь төвлөрсөн усан хангамжтай, 70% нь хөргөгч, хөлдөөх төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагаа хангагдаж, хадгалах нөхцлийн эрүүл ахуйн шаардлага хангасан байна. Эрүүл ахуй, ариун цэврийн шаардлага

хангахгүй нөхцөлд үйл ажиллагаа эрхэлж байсан 1 гуанзны үйл ажиллагааг зогсоож, хадгалалтын хугацаа дууссан, чанар, аюулгүй байдлаа алдсан 23 нэр төрлийн 382,7 мянган төгрөгийн хүнсний бараа бүтээгдэхүүнийг устгах арга хэмжээ авсан байна.

3. Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайдтай байгуулсан гэрээнд: „40 мянган орон сууц,, хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилт 75,0 хувьтай гэсэн нь:

Орон сууц хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд аймгийн хэмжээнд 2009 оны эхэнд аймгийн төв Сайншанд сумын 1 дүгээр багийн нутаг дэвсгэрт орон сууцны бичил хороололд хувийн болон орон сууц санхүүжилтийн корпорацийн хөрөнгө оруулалтаар 60, 30, 30, 65 айлын, 2 дугаар багийн нутаг дэвсгэрт 20 айлын нийтийн орон сууцны барилгууд баригдаж байсан.

Замын- Үүд сумын 1 дүгээр багийн нутаг дэвсгэрт хувийн хөрөнгө оруулалтаар 38, 48 айлын нийтийн орон сууцны барилгууд баригдаж байсан. 2009 оны сүүлийн хагас жилд Замын-Үүд суманд цагдаагийн ажилчдын 96 айлын нийтийн орон сууц, шүүхийн ажилчдын 48 айлын нийтийн орон сууц, багш нарын 30 айлын нийтийн орон сууцны барилгууд баригдаж эхэлсэн байна.

Сайншанд сумын 2 дугаар багийн нутаг дэвсгэрт орон сууцны санхүүжилтийн корпорацийн хөрөнгө оруулалтаар баригдаж байгаа 20 айлын нийтийн орон сууцны барилга 2009 оны 7 дугаар сард ашиглалтанд орсон. Сайншанд сумын 1 дүгээр багийн нутаг дэвсгэрт хувийн хөрөнгө оруулалтаар баригдаж байгаа 30 айлын орон сууц 2009 оны 11 дүгээр сард ашиглалтанд орсон.

Замын-Үүд сумын 1 дүгээр багийн нутаг дэвсгэрт хувийн хөрөнгө оруулалтаар “Тулга констракшн” ХХК-ийн барьж буй нийтийн 32 айлын орон сууцны барилга 2009 оны 10 дугаар сард хэсэгчилэн ашиглалтанд орсон байна. Мөн багт “Говь-баяннуур” ХХК-ийн барьж буй 48 айлын нийтийн орон сууцны барилгын дотор заслын ажил үргэлжлэн хийгдэж байна.

2009 онд аймгийн хэмжээнд ашиглалтанд орохоор төлөвлөгдөж байсан орон сууцны барилгуудын 75,0 хувь нь ашиглалтанд орсноор гэрээний үүргийн биелэлтийг тооцсон болно.

4. Байгаль орчин, аялал жуулчлалын сайдтай байгуулсан гэрээнд: Ойжуулалтын ажил 76,3 хувьтай гэсэн нь:

Аймгийн дүнгээр 36,6 мянган мод, суулгац тариалсан, Сайншанд сумын ойн зурвасыг өргөтгөсөн, хүлэмж байгуулсан, 5,0 мянган ш суулгац бэлтгэх боломжийг бүрдүүлсэн, „Ногоон хэрэм,, хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, 10 га талбайд ойн зурвас шинээр байгуулсан, түүнд 9,1 мянган мод тарьсан зэргээр ногоон байгууламжийг өргөтгөх ажил өмнөх жилийнхээс буураагүй байна. Харин нийт тарьсан суулгацын амьдарч байгаа хувиар гэрээний үүргийн биелэлтийг тооцжээ. Говийн нөхцөлд мод, бут, таримлыг суулгаад арчилж тордох ажил туйлын чухал, үүний дотор усны асуудал бэрхшээлтэйгээс үүдэн амьдралт 76,3 хувьтай байна

Дорноговь аймгийн Засаг даргаас төсвийн ерөнхийлөн захирагч нартай байгуулсан гэрээний үүргийн биелэлтийн мэдээ

2010.02.22

№	Төсвийн ерөнхийлөн захирагч нар	Гэрээний үүргийн биелэлтийг тооцсон гол үзүүлэлт	Биелэлтийн хувь	Үнэлгээний оноо
1	Монгол улсын Шадар сайд	1. Стандартчилал, хэмжил зүйн үйлчилгээний хүрээнд - Хэмжих хэрэгслийн баталгаажуулалт - Чанарын баталгаажуулалт - Стандартын салбар сангийн үйлчилгээ - Сорилт шинжилгээ 2. Хүүхэд хамгаалах, хөгжлийг дэмжих ажил, үйлчилгээ Багцын дүн	85.0 90.0 95.0 90.0 95.0 92.5	4.62
2	Хууль зүй, дотоод хэргийн сайд	- Хууль зүйн сургалт, сурталчилгаа - Гэмт хэргийн гаралтыг бууруулах талаар зохиосон ажил - Олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх ажил - Хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн дундаж хувь Багцын дүн	90.0 90.0 90.0 88.7 89.6	4.48
3	Хүнс, ХААЖДҮ-ийн сайд	- Мал сүргийн тоо толгойг өсгөх, чанарыг сайжруулах зорилт - Бэлчээрийн мал аж ахуйн эрсдлийг бууруулах ажил - Газар тариалангийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх бодлогын хэрэгжилт - Мал эмнэлгийн ажил, үйлчилгээ - Хүнсний бүтээгдэхүүний хангамж, чанар, аюулгүй байдлыг хангах талаар зохиосон ажил - “Атрын-3 дахь аян” агро парк төслийг хэрэгжүүлсэн байдал Багцын дүн	100.0 97.0 100.0 95.2 74.0 100.0 94.3	4.71
4	Зам тээвэр, барилга, хот байгуулалтын сайд	- “40 мянган айлын орон сууц” хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилтын биелэлт - “Орон нутгийн хотуудын нийтийн аж ахуйг хөгжүүлэх хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх ажил - “Орон сууц” аймгийн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажил - Аймгийн ХББЗА хяналт тавьж байгаа төсөл, арга хэмжээний хэрэгжилт Багцын дүн	75.0 100.0 90.0 100.0 91.2	4.56
5	Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд	- Нийгмийн халамж, хамгааллын талаар төр, засгийн гаргасан бодлогыг хэрэгжүүлэх ажил, үйлчилгээ - Мэргэжил олгох, мэргэжил дээшлүүлэх ажил, үйлчилгээ - Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байр шинээр нээх зорилтын	100.0 100.0	

		биелэлт	96.0	
		Багцын дүн	98.6	4.93
6	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд	<ul style="list-style-type: none"> - Ойжуулалт - Ус цаг уур, орчны шинжилгээ, мэдээллийн үйлчилгээ - Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ 	76.3 97.5 100.0	4.56
		Багцын дүн	91.2	
7	Эрүүл мэндийн сайд	<ul style="list-style-type: none"> - Мэргэжлийн боловсон хүчний хангалт, чадваржуулах, мэргэшүүлэх ажил, үйлчилгээ - Эх, хүүхдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний үр дүн - Урьдчилган сэргийлэх үйлчилгээ 	92.0 90.0 95.0	4.61
		Багцын дүн	92.3	
8	Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд	<ol style="list-style-type: none"> 1. Сургуулийн өмнөх боловсрол <ul style="list-style-type: none"> - Хамран сургалтын хувь /хүрэх түвшний үзүүлэлт / - Хувилбарт сургалтын хамран сургалт /хүрэх түвшний гүйцэтгэлийн хувь/ - Мэргэжлийн багшийн хангалт /хүрэх түвшний/ 2. Ерөнхий боловсролын сургууль <ul style="list-style-type: none"> - Суурь боловсролын хамран сургалт /хүрэх түвшний/ - Мэргэжлийн багшийн хангалт - Бичиг үсгийн боловсролд хамрагдалт /зорилтын биелэлт/ 	100.0 84.3 99.2 85.4 99.2 100.0	4.73
		Багцын дүн	94.6	
9	Батлан хамгаалахын сайд	<ul style="list-style-type: none"> - Хууль тогтоомжийг сурталчлах, хэргэжүүлэх, зохион байгуулах, хэрэгжилтэнд хяналт тавих - Цэргийн үүрэгтний бүртгэл хөтлөх, сургаж бэлтгэх, сургалтын материаллаг баазыг бэхжүүлэх, цэрэг татлага зохион байгуулах, цэргийн албыг дүйцүүлэн хааж буй иргэдэд сургалт явуулах - Дайчилгааны төлөвлөгөөг тодотгож баталгаажуулах, даалгаваржуулах, дайчилгааны бэлтгэл нөөцийн сургалтыг зохион байгуулах 	95.0 98.0 95.0	4.80
		Багцын дүн	96.0	
Гүйцэтгэлийн дундаж оноо /хувиар/				93.3
Үнэлгээний оноо				4.66

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

Дорноговь аймгийн Засаг даргаас төсвийн ерөнхийлөн захирагч нартай байгуулсан гэрээний үүргийн биелэлтийн дэлгэрэнгүй мэдээлэл

2010.02.27

№	Төсвийн ерөнхийлөн захирагч нар	Гэрээний үүргийн биелэлтийг тооцсон гол үзүүлэлтүүд	Биелэлт	Биелэлтийн хувь
1	Монгол Улсын Шадар сайд	1. Стандартчилал, хэмжил зүйн үйлчилгээний хүрээнд		
		Хэмжих хэрэгслийн баталгаажуулалт	Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах ажил, үйлчилгээг өргөжүүлэх чиглэлээр арга хэмжээ авч, цахилгаан тоолуур, хий шингэний эзэлхүүн, цулын зэрэг 15 төрлийн хэмжих хэрэгслийн чиглэлээр давхардсан тоогоор 518 аж ахуйн нэгж, 1541 хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн 2726 хэмжих хэрэгслийг хамруулж улсын баталгаажуулалт хийв. Хэмжүүрийн баталгаажуулалтанд нийт 7061.5 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн байна.	85.0
		Чанарын баталгаажуулалт	Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй байгууллагуудаас 2009 оны жилийн эцсийн байдлаар 311 аж ахуйн нэгж, 9 байгууллага, 186 хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн үйлчилгээ, тэдгээрийн үйлдвэрлэж байгаа, худалдан борлуулж буй эх орны болон импортын хүнсний бүтээгдэхүүнийг улсын баталгаажуулалтад хамруулав.	90.0
Стандартын салбар сангийн үйлчилгээ	Бүтээгдэхүүн үйлдвэрлэгч болон үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийг, Үндэсний болон Олон улсын стандартаар хангаж ажиллав. Стандартын салбар сангаар нийт 38 аж ахуйн нэгж, байгууллага, 16 хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд гарын авлага, заавар, зөвлөгөө өгч, тэдэнд 6 төрлийн стандартын баримт бичгээр хангаж	95.0		

		үйлчлэв. Стандартын сангаар үйлчлүүлсэн үйл ажиллагаанаас 438.7 мянган төгрөгийн орлого бүрдүүлэв. Стандартын салбар санг 112 ш Монгол Улсын үндэсний стандартаар баяжуулав.	
	Сорилт шинжилгээ	Нэгдсэн сорилтын лабораториуд нь 2009 оны жилийн эцсийн байдлаар нийт 563 аж ахуйн нэгж, хувийн худалдаачин, байгууллага, 302 нэр төрлийн бүтээгдэхүүний 2230 дээж сорьцод сорилтын шиэжилгээ хийсэн байна.	90.0
	Хүүхэд хамгаалах, хөгжлийг дэмжих ажил, үйлчилгээ	“Бид хамтдаа”сэдэвт аймгийн хүүхдийн IY чуулганыг 12- р сарын 17-18-ны өдрүүдэд ХТҮГ, аймгийн ЗДТГ, Дэлхийн зөн ,Хүүхдийн төлөө хэлтэс, Хүүхдийн нэгдсэн зөвлөл хамтран зохион байгуулав. “Бид хамтдаа” чуулганд 14 сумын 80 гаруй хүүхэд, ЕБС-ийн нийгмийн ажилтнууд, сумдын нийгмийн асуудал хариуцсан бодлогын түшмэл, хүүхдийн байцаагч зэрэг хүүхдийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй байгууллагуудын 50 гаруй төлөөлөл оролцож, хүүхдэд тулгамдаж буй асуудал, хүүхдийн хамгаалал сайжруулах, оролцоог хангахад насанд хүрэгчдийн үүрэг хариуцлагыг хэрхэн дээшлүүлэх, хүүхэд өөрийгөө хэрхэн хөгжүүлэх зэрэг асуудлаар хэлэлцүүлэг явуулж, чуулганы шийдвэрт тусгуулсан. Хүүхдийг хөгжүүлэх чиглэлээр: Өсвөрийн шатарчдын “Цодгор хүү 2009” тэмцээн, Уран уншлагын “Уран жиргээ 2009” уралдаан, Ардын болон хүүхдийн дуу дуулаачдын “Дуулах өв” уралдаан, Хүүхдийн урлагын “Яргуй 2009” наадам, “Хүүхдийн ертөнц 2009” зургийн уралдаан, Зохиолын болон хүүхдийн дуу дуулаачдын “Дагаад дуулаарай” уралдаан, Хүүхдийн спортын наадам, Хүүхдийн бүтээлийн үзэсгэлэн, СӨБ-ын хүүхдийн дунд “Говь нутгийн дэг” хамтлаг бүжгийн тэмцээнүүдийг зохион байгуулж 4000 гаруй хүүхэд хамрагдав. Хүүхдийн оролцооны байгууллагуудтай хамтран ЕБС-ийн сурагчид болон МСҮТ-ийн оюутнуудын дунд Уран илтгэгчийн	95.0

			<p>тэмцээн, “Алтан хонх”, “Сайн үйлс-Цэвэр орчин” нийтийн цэвэрлэгээ, “Гялгар уутнаас татгалзъя” аянуудыг зохион байгуулсан. Хүүхэд өсвөр үеийнхний бие бялдарыг хөгжүүлэх, нутаг орныхоо байгаль орчинтой танилцах, хайрлан хамгаалах үзлийг төлөвшүүлэх зорилгоор хүүхдийн явган аялал, дугуйн аялалыг зохион байгуулж МСҮТ, Зүүнбаян болон 1,2,3-р сургуулийн 80 гаруй сурагчдыг хамруулав. Аймгийн Засаг даргын захирамжаар “Жаргалан” зуслангийн зарим тоног төхөөрөмжийг шинэчлэн хөрөнгийн асуудлыг шийдвэрлэж 2009 оны зун нийт 50 гаруй хүүхдийг амраасны 2 нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд байлаа.</p>	
2	Хууль зүй, дотоод хэргийн сайд	Хууль зүйн сургалт, сурталчилгаа	<p>Цагдаагийн газар нь “Нээлттэй өдөр”-ийг Айраг, Даланжаргалан, Өргөн, Эрдэнэ, Хөвсгөл, Хатанбулаг, Замын-Үүд суманд 7 удаа зохион явуулав. Нээлттэй өдрөөр сумын иргэдэд Цагдаагийн газраас 2009 оны эхний 11 сард хийсэн ажлыг тайлагнаж, аймгийн эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдлын талаарх мэдээллийг танилцуулсан. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор ухуулга сурталчилгааг 321 удаа 22775 хүнд хийж, зурагт хуудас 1038ш, санамж, зөвлөгөө 1574ш, сэрэмжлүүлэг 1771ш, гарын авлага 388 ширхэгийг тарааж, замын цагдаа, хэв журмын албанаас үзүүлэх ажил үйлчилгээг нэг цэгт төвлөрүүлэн хүргэж, иргэдээс санал хүсэлтийг хайрцгаар болон асуулгын хуудсаар авч хууль зүйн зөвлөгөө өглөө.</p> <p>“Миний нутаг” FM 101.5 радиотой хамтран “Дуудлага” шууд ярилцлагыг долоо хоног бүрийн баасан гаригийн 18.40-19.30 цагийн хооронд тасаг албадаас хуваарийн дагуу тогтмол явуулж байна.”Дуудлага” шууд нэвтрүүлгээр 2009 оны техникийн үзлэг тооллогын тухай, Хөдөлгөөний соёл, сахилга, Явган зорчигчийн үүрэг, 2009 оны эхний</p>	90.0

			<p>хагас жилд үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчилд хийсэн дүгнэлтийн талаар, Насанд хүрээгүй хүүхдээс үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөл, Гэр бүлийн хүчирхийллийн тухай тухай ойлголт, Сайншанд суманд архидан согтуурахтай тэмцэх чиглэлээр зохиож буй ажлын талаар, Согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, байгууллагын хүлээх үүрэг, хариуцлага, Нийгмийн дэг журам хангах талаар аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс баримталж ажиллах журам, Архидан согтуурахын хор уршиг зэрэг сэдвээр 15 удаа явуулж иргэдээс эфирийн шууд утсаар 46 асуулт хүлээн авч хариултыг өгч шийдвэрлэсэн.</p>	
		<p>Гэмт хэргийн гаралтыг бууруулах талаар зохиосон ажил</p>	<p>Тус аймагт үйлдэгдсэн гэмт хэргийн ихэнх хувийг Иргэдийн эрх чөлөө, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг эзэлж байна. Сүүлийн 3 жилийн байдлаар судалгаа дүгнэлт хийн мэдээллийг аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн байна. Мөн оюутан, сурагчдыг архидан согтуурах, гэмт хэрэг зөрчилд холбогдохоос урьдчилан сэргийлэх талаар Цагдаагийн газраас авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаарх мэдээллийг аймгийн ГХУСАЗСЗөвлөлөөр хэлэлцүүлсэн.</p> <p>Аймгийн хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэрэг, эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдлын мэдээллийг сар тутам орон нутгийн удирдлагуудад хүргүүлж байлаа.</p> <p>Цаашид гэмт хэргийн гаралтыг сааруулах, гэмт хэрэгт татагдан орж болзошгүй, эрхэлсэн ажил, сургуульгүй, хорих ял эдлээд суллагдсан хүмүүсийг нийгмийн дунд төлөвшихөд нь орон нутгийн төр захиргааны байгууллага, төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллаж, иргэд нийгэмд хор уршиг тодорхой хэмжээгээр учруулж, бусад хэрэгтэй харьцуулахад өсөлттэй байгаа гэмт хэрэгтэй</p>	<p>90.0</p>

		Олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх ажил	<p>тэмцэх онцгой анхаарч ажиллалаа.</p> <p>Гудамж талбай, олон нийтийн газарт хяналт тавих цагдаагийн эргүүлийн үйл ажиллагааг хүйтэний болон дулааны улирлын нэгдсэн байршилтаар зохион байгуулж, эргүүлд давхардсан тоогоор 2479 офицер, 4205 ахлагч, нийт 6684 алба хаагч 8740 цаг үүрэг гүйцэтгэж, 366 автомашин, мотоцикль, 1117 гар станц, бусад тусгай хэрэгсэл ашигласан.</p> <p>Аймгийн төв буюу Сайншанд сумын худалдаа, үйлчилгээний газрууд, хүн, тээврийн хэрэгслийн хөдөлгөөн ихтэй зарим гудамж талбайг хяналтанд авах, тэнд гэмт хэрэг, хэв журмын зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор 1, 2 дугаар багийн нутаг дэвсгэрийн зааг газарт цагдаагийн хяналтын цэгийг шинээр байгуулж, 12.00-20.00 цагийн хооронд харуул ажиллуулсан нь үр дүнгээ өгч гудамж талбайд үйлдэгдсэн гэмт хэрэг өнгөрсөн оны мөн үеэс 7,7 хувиар буурсан.</p> <p>Цагдаагийн эргүүлээс гудамж талбай, олон нийтийн газарт тавих хяналтыг нэмэгдүүлэх, гэр хороолол болон алслагдсан газарт цагдаагийн эргүүлийг хүргэх, иргэдийн амгалан тайван амьдрах нөхцлийг бүрдүүлэх ажилд ахиц гаргах зорилгоор цагдаагийн газрын төвийн тасаг, албадын алба хаагчдыг 7 хоногт 1 удаа 4 цагаар эргүүлд гаргаж гудамж талбайд үйлдэгдэх гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох ажилд татан оролцуулсан.</p> <p>2009 онд аймгийн хэмжээнд нийгмийн хэв журам хамгаалах олон нийтийн байцаагч 19 хүнийг ажиллуулж цагдаагийн хэсгийн байцаагч, төлөөлөгч өдөр тутам мэргэжлийн удирдлагаар ханган, ажлын үр дүнг тооцон ажилласан байна. Нийтийн эргүүлд 541 байгууллага, аж ахуйн нэгжээс 2977 хүнийг хуваарийн дагуу ажиллуулж, 36 зөрчил илрүүлэн эрх бүхий албан хаагч нар зөрчлийг</p>	90.0
--	--	--	--	------

			шийдвэрлэсэн байна.	
		Хөтөлбөрүүдийн дундаж хувь	хэрэгжилтийн	88.7
			-Авилгатай тэмцэх хөтөлбөрийн биелэлт-90,6, -Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийн биелэлт-90,2, -Архидан согтуурахаас урьдчилан сэргийлэх, хяналт тавих тухай үндэсний хөтөлбөрийн биелэлт-90,0, -Замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үндэсний хөтөлбөрийн биелэлт-84,0 Нийт хөтөлбөрүүдийн биелэлт-88,7 хувь буюу "В" үнэлгээтэй хэрэгжсэн байна.	
3	Хүнс, ХААЖДҮ-ийн сайд	Мал сүргийн тоо толгойг өсгөх, чанарыг сайжруулах зорилт		100.0
		Бэлчээрийн мал аж ахуйн эрсдлийг бууруулах ажил	2009 онд 1076.9 мянган толгой малтай болж таван төрөлд 115.5 хувиар өссөн байна. Цэвэр үүлдэр, эрлийз нутгийн шилдэг омгийн малын тоо 2009 онд 359900 болж 55.3 хувиар өссөн байна. ХХААЖДҮГазар Төв аймгийн Баянчандмань сумаас махны чиглэлээр торгууд монголын эрлийз хуц 1, Завхан буурал сүүний чиглэлийн ухна 4-ийг ОНТ-ийн 781.9 мянган төгрөгийн хөрөнгөөр худалдан авсан. Аймгийн хэмжээнд 1788 малчин өрх, 8 аж ахуйн нэгж байгууллага, 1185,2тн өвс, 238,2тн гар тэжээл бэлтгэж өөрсдийн хэрэгцээндээ нөөцлөөд байна. Тогтвортой амьжиргаа 2 төслийн хүрээнд бэлчээрийн менежментийг сайжруулах талаар Хөвсгөл сумыг загвар сумаар сонгон 10га газрыг хашаажуулаад байна. Цөлжилттэй тэнцэх газрын тогтвортой менежент хөрөнгийн эх үүсвэрээр Алтанширээ суманд 2 га хадлангын талбайг хашиж сайжруулах, малын тэжээлийн ургамал тариалах төслийн шалгарлаар Өргөн суманд 10га хашиж, хамгаалан цөлжилттэй тэнцэх тогтвортой менежментийг төслийн хөрөнгийн эх үүсвэрээр Дэлгэрэх сумын Хонгорын худагыг төсөлжүүлж 2.2га талбайг хашаажуулж олон наст ургамлыг тариалсан. Иххэт сумын Хүйтэний булагийн услалтын системийг түшиглүүлж " ГЦБС"-ХХК-д 12 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын дэмжлэг үзүүлж 20га талбайг	97.0

		хамааруулж, бороожуулах усалгааны системтэй болсон.	
	Газар тариалангийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх бодлогын хэрэгжилт	Өрхийн тариаланчдад дэмжлэг үзүүлэх зорилгоор аймгийн Засаг даргын 175 дугаар захирамжаар “Шинэ Дорноговь” хөгжлийн сангаас 7.7 сая төгрөгийн хөрөнгө гарган Романа сортын үрийн төмс 10 тонныг авч тариаланчдад олгов. Аймгийн Засаг даргын дэмжлэгээр 2009 онд газар тариалангийн үйлдвэрлэлийг дэмжсэн бодлого, зохицуулалтын 6 удаагийн захирамж гарган хэрэгжүүлж ажилласнаар энэ онд 54 аж ахуйн нэгж байгууллага, 441 өрх, 54.5 га-д төмс, 38.4 га-д хүнсний ногоо, тэжээлийн ургамал 7.3 га-д тус тус тариалж 222.7 тн төмс, 201.0 тн хүнсний ногоо, 89.5 тн тэжээлийн ургамал хураан авсан байна. Ургацын байдлаар нь авч үзвэл 14 % сонгино, 6.9 % байцаа, 5.9 % манжин, 4 % шар лууван, 12.6 % өргөст хэмх, 51.6 % тарвас 5 % бусад ногоо эзэлж байна. Дээрх байдлаас үзэхэд манай аймгийн нөхцөлд тарвасыг голчлон тариалж илүү өндөр ургац авч байна.	100.0
	Мал эмнэлгийн ажил, үйлчилгээ	Малын халдварт өвчнөөс сэргийлэх тарилганд 318 мянган мал, паразитгах өвчнөөс сэргийлэх тарилганд 85.7 мянган малыг хамрууллаа. Малын гоц халдварт Цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгыг 129.8 хонинд, шүлхий өвчнөөс сэргийлэх тарилгыг 414.7 мянган малд хийлээ. Аймгийн нийт мал эмнэлгийн үржлийн ажил үйлчилгээний нэгжийн бүтэц үйл ажиллагааны MNS-5368-2004 стандартын түвшин тогтоох шалгалтаар 1-р зэрэглэлийн 1, 2-р зэрэглэлийн 10, 3-р зэрэглэлийн 8 нэгж тогтоогдсон байна.	95.2
	Хүнсний бүтээгдэхүүн хангамж, чанар, аюулгүй байдлыг хангах талаар зохиосон ажил	Монгол улсын Засгийн газрын “Хүнсний хангамж, аюулгүй байдал, хоол тэжээл” хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлэх ажлыг аймгийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг хариуцан зохион байгуулж	74.0

		<p>байна. Хөтөлбөрийн хүрээнд гүйцэтгэх ажлын төлөвлөгөө гарган сум, багийн өдөрлөг дээр Хүнсний хангамж, аюулгүй байдал, чанарын талаархи сурталчилгааг холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран хийж, жижиг дунд үйлдвэрлэл, худалдаа эрхлэгчдийг ажлын байрны аттестатчилалд хамруулан бүтээгдэхүүний чанар, аюулгүй ажиллагааг сайжруулах үүднээс техник технологио шинэчлэх, үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, үйлдвэрлэгчдийг чадваржуулахад анхааран бодлогын түвшинд дэмжин заавар зөвлөмж өгч ажиллаж байна. Хүнсний хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх ажлын хүрээнд “Дорноговь түншлэл-2009” бүтээгдэхүүн үйлчилгээний үзэсгэлэн худалдааг 2009.09.15,16-ны өдрүүдэд аймгийн төвд зохион байгуулахад 14 сумын 27 аж ахуйн нэгж, 77 иргэн 400 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүнээр оролцсоныг 13 номинацаар шалгаруулж, “Намрын ногоон өдрүүд” хүнс, хөнгөн үйлдвэрийн бүтээгдэхүүн болон жимс, хүнсний ногооны үзэсгэлэн худалдаанд “Талын нүдэн” ХХК айрагны цахилгаан бүлүүрээр, Эрдэнэ сумын “Мөрөөдлийн говь” ХХК нь 40 тн, Мандах сумын “Монгол тарвас” ХХК 5 тн тарвасаар тус тус оролцлоо. Мөн Төвийн бүсийн аймгуудын “Дархан түншлэл-2009” үзэсгэлэн худалдаанд Замын-Үүд сумын Стар-Овоот талх, нарийн боовны цех нь аймгаа төлөөлөн амжилттай оролцоод ирсэн. Энэхүү арга хэмжээнүүдэд нийт 1600.0 мянган төгрөгийг зарцуулсан. Хүнсний хангамж хүртээмжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд ЖДҮ-ийг дэмжих сангийн төсөл хөтөлбөрт аж ахуйн нэгж иргэдийг хамруулан хүнсний 7 цехэд 66.5 сая, сүүний үйлдвэрлэл фермерийн чиглэлээр 6 иргэн 142.0 сая, худалдаа үйлчилгээний 20 газарт үйлдвэрлэл үйлчилгээ өргөтгөх, шинэчлэх ажилд хөнгөлөлтэй зээлийн санхүүжилт олгон ажиллаж байна.</p>	
--	--	---	--

		“Атрын-3 дахь аян” агро парк төслийг хэрэгжүүлсэн байдал	“Атрын-3 дахь аян” тариалангийн хөгжлийн хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлж 10 сумын агропарк ашиглагчтай гэрээ байгуулж, 21 сургалт зохион байгуулж давхардсан тоогоор 471 иргэдийг хамруулав. Дээрх ажлыг зохион байгуулж ажилласнаар агропаркийн 9 хүлэмжинд 2086 кг ургац авч 16017.0 мянган төгрөгийн орлого олсон. “Агропарк” төслийг орон нутагтаа хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулж ажилласнаар 12 сум нийт дүнгээр 430 тоннын багтаамжтай зоорьтой болсон, 9 сумын агропарк хэвийн үйл ажиллагаа явуулж байна.	100.0
4	Зам тээвэр, барилга, хот байгуулалтын сайд	“40 мянган айлын орон сууц” хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилтын биелэлт	Орон сууц үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд аймгийн Засаг даргын 2005 оны 328 тоот захирамжаар “Орон сууц” дэд хөтөлбөрийг батлуулан хэрэгжүүлэн ажилласан. Тус хөтөлбөрийн хүрээнд Сайншанд сумын 1 дүгээр багийн нутаг дэвсгэр Ноён хутагтын гудамжинд 60 айлын орон сууц /БНХАУ-ын “Мон Ли да” ХХК, 2003 он/, Шинэ зууны гудамжинд 60 айлын орон сууц /“Тулга констракшин” ХХК, 2006 он/, үйлчилгээний төвтэй 64 айлын орон сууц /“БатС-Өргөө” ХХК, 2008 он/, 30 айлын орон сууц /“Говь баяннуур” ХХК, 2009 он/, 4 дүгээр багт 60 айлын орон сууц /“Тулга констракшин” ХХК, 2007 он/, 2 дугаар багт 20 айлын орон сууц / “Боршоон-Ундраа” ХХК, 2009 он/-ны барилгууд тус тус баригдаж ашиглалтад орсон. Мөн Замын-Үүд суманд хувийн хөрөнгө оруулалтаар 64, 32, 48, 10, 10, 24, 8 айлын орон сууцны барилгууд тус тус баригдаж ашиглалтад орсон байна. 2009 оны жилийн эцэст Сайншанд суманд 60, 65 айлын угсармал орон сууц /Тулга констракшн ХХК/, 30 айлын орон сууц /ТОБЭМ ХХК, ОССК/, Замын-Үүд суманд Цагдаагийн ажилчдын 96, Шүүхийн 48, Багш нарын 30 айлын орон сууцны барилгын ажлууд үргэлжлэн явагдаж байна. Тухайн хөтөлбөрийн хэрэгжилтийн хугацаанд	75.0
		“Орон нутгийн хотуудын нийтийн аж ахуйг хөгжүүлэх хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх ажил	Сайншанд сумын 1 дүгээр багийн нутаг дэвсгэр Ноён хутагтын гудамжинд 60 айлын орон сууц /БНХАУ-ын “Мон Ли да” ХХК, 2003 он/, Шинэ зууны гудамжинд 60 айлын орон сууц /“Тулга констракшин” ХХК, 2006 он/, үйлчилгээний төвтэй 64 айлын орон сууц /“БатС-Өргөө” ХХК, 2008 он/, 30 айлын орон сууц /“Говь баяннуур” ХХК, 2009 он/, 4 дүгээр багт 60 айлын орон сууц /“Тулга констракшин” ХХК, 2007 он/, 2 дугаар багт 20 айлын орон сууц / “Боршоон-Ундраа” ХХК, 2009 он/-ны барилгууд тус тус баригдаж ашиглалтад орсон. Мөн Замын-Үүд суманд хувийн хөрөнгө оруулалтаар 64, 32, 48, 10, 10, 24, 8 айлын орон сууцны барилгууд тус тус баригдаж ашиглалтад орсон байна. 2009 оны жилийн эцэст Сайншанд суманд 60, 65 айлын угсармал орон сууц /Тулга констракшн ХХК/, 30 айлын орон сууц /ТОБЭМ ХХК, ОССК/, Замын-Үүд суманд Цагдаагийн ажилчдын 96, Шүүхийн 48, Багш нарын 30 айлын орон сууцны барилгын ажлууд үргэлжлэн явагдаж байна. Тухайн хөтөлбөрийн хэрэгжилтийн хугацаанд	100.0
		“Орон сууц” аймгийн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажил	Сайншанд сумын 1 дүгээр багийн нутаг дэвсгэр Ноён хутагтын гудамжинд 60 айлын орон сууц /БНХАУ-ын “Мон Ли да” ХХК, 2003 он/, Шинэ зууны гудамжинд 60 айлын орон сууц /“Тулга констракшин” ХХК, 2006 он/, үйлчилгээний төвтэй 64 айлын орон сууц /“БатС-Өргөө” ХХК, 2008 он/, 30 айлын орон сууц /“Говь баяннуур” ХХК, 2009 он/, 4 дүгээр багт 60 айлын орон сууц /“Тулга констракшин” ХХК, 2007 он/, 2 дугаар багт 20 айлын орон сууц / “Боршоон-Ундраа” ХХК, 2009 он/-ны барилгууд тус тус баригдаж ашиглалтад орсон. Мөн Замын-Үүд суманд хувийн хөрөнгө оруулалтаар 64, 32, 48, 10, 10, 24, 8 айлын орон сууцны барилгууд тус тус баригдаж ашиглалтад орсон байна. 2009 оны жилийн эцэст Сайншанд суманд 60, 65 айлын угсармал орон сууц /Тулга констракшн ХХК/, 30 айлын орон сууц /ТОБЭМ ХХК, ОССК/, Замын-Үүд суманд Цагдаагийн ажилчдын 96, Шүүхийн 48, Багш нарын 30 айлын орон сууцны барилгын ажлууд үргэлжлэн явагдаж байна. Тухайн хөтөлбөрийн хэрэгжилтийн хугацаанд	90.0
		Аймгийн ХББЗА хяналт тавьж байгаа төсөл, арга хэмжээний хэрэгжилт	Сайншанд сумын 1 дүгээр багийн нутаг дэвсгэр Ноён хутагтын гудамжинд 60 айлын орон сууц /БНХАУ-ын “Мон Ли да” ХХК, 2003 он/, Шинэ зууны гудамжинд 60 айлын орон сууц /“Тулга констракшин” ХХК, 2006 он/, үйлчилгээний төвтэй 64 айлын орон сууц /“БатС-Өргөө” ХХК, 2008 он/, 30 айлын орон сууц /“Говь баяннуур” ХХК, 2009 он/, 4 дүгээр багт 60 айлын орон сууц /“Тулга констракшин” ХХК, 2007 он/, 2 дугаар багт 20 айлын орон сууц / “Боршоон-Ундраа” ХХК, 2009 он/-ны барилгууд тус тус баригдаж ашиглалтад орсон. Мөн Замын-Үүд суманд хувийн хөрөнгө оруулалтаар 64, 32, 48, 10, 10, 24, 8 айлын орон сууцны барилгууд тус тус баригдаж ашиглалтад орсон байна. 2009 оны жилийн эцэст Сайншанд суманд 60, 65 айлын угсармал орон сууц /Тулга констракшн ХХК/, 30 айлын орон сууц /ТОБЭМ ХХК, ОССК/, Замын-Үүд суманд Цагдаагийн ажилчдын 96, Шүүхийн 48, Багш нарын 30 айлын орон сууцны барилгын ажлууд үргэлжлэн явагдаж байна. Тухайн хөтөлбөрийн хэрэгжилтийн хугацаанд	100.0

			<p>аймгийн орон сууцны фонд 500 гаруй айлаар нэмэгдсэн байна.</p> <p>2009 онд аймгийн хэмжээнд улсын болон орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөрийн хүрээнд 39 объектод 2534751.4 мянган төгрөгийн барилга угсралт их засварын ажил хийгдсэн байна. Хөрөнгө оруулалтыг эх үүсвэрээр нь ангилж үзвэл: Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 1805252.4 мянган төгрөг, Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 77953.0 мянган төгрөг, Тогтвортой амьжиргаа-2 төслийн хөрөнгөөр 214046.1 мянган төгрөг, Боловсрол хөгжил хөтөлбөрийн хүрээнд олон улсын байгууллагын зээл тусламжийн хөрөнгө оруулалтаар 437499.9 мянган төгрөг. Хөрөнгө оруулалтын ажлын 93.2 % ондоо багтаж бүрэн хэрэгжсэн. Саран хөхөө театрын барилгын өргөтгөл, шинэчлэлт, Сайншанд сумын 150 ортой цэцэрлэг, Сайншанд сумын ЕБ-ын 3 дугаар сургуулийн спорт заал, Сайншанд сумын ЕБ-ын 920 хүүхдийн сургуулийн барилга угсралтын ажлууд он дамжин хэрэгжиж байна.</p>	
5	Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд	Нийгмийн халамж, хамгааллын талаар төр, засгийн гаргасан бодлогыг хэрэгжүүлэх ажил, үйлчилгээ	<p>2009 оны 02 сарын 15-ны өдрөөс эхлэн сум бүрт хөдөлмөр халамжийн үйлчилгээ хариуцсан 17 нийгмийн ажилтан ажиллаж байна. Эдгээр ажилтнуудыг чадавхижуулах сургалтыг 4 удаа зохион байгуулж гарын авлага, хуулийн эмхэтгэл, зөөврийн компьютер, принтерээр хангаж, үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөл бололцоог бүрдүүлсэнээр хүн амд хүргэх нийгмийн халамжийн үйлчилгээний чанар, хүртээмж дээшилсэн.</p> <p>Нийгмийн халамжийн дэмжлэг тусалцаа шаардлагатай иргэнд үзүүлэх хөнгөлөлт, нөхцөлт мөнгөн тэтгэмжинд 1102 иргэнд 122,9 сая төгрөгийг хуулийн дагуу цаг хугацаанд нь олгов. Хүүхдийн мөнгөн тэтгэмжид 20181 хүүхдэд 715,2 сая төгрөг, шинээр төрсөн 1207 хүүхдэд 153,3 сая төгрөг,</p>	100.0

		шинээр гэр бүл бологсад 463 хүнд 338,8 сая төгрөг, хүүхдийн хөгжлийн мөнгөн тусламжид 20181 хүүхдэд 2 тэрбум төгрөг , алдарт эхийн одонтой 2925 хүнд 181,6 сая төгрөгийг тус тус олгосон байна.	
	Мэргэжил олгох, мэргэжил дээшлүүлэх ажил, үйлчилгээ	19 удаагийн мэргэжил олгох сургалтанд 420 иргэнийг хамруулан 48810,8 мянган төгрөгийг хөдөлмөр эрхэлтийг дэмжих сангаас зарцуулав. Мэргэжлийн сургалт төгсөгчдөөс 247 иргэн нь сургалтын дараа хөдөлмөр эрхэлж байна. Аж ахуй эрхлэх бизнесийн сургалтанд 94 иргэнийг, төсөл хөтөлбөр боловсруулах сургалтанд 35 иргэн, малчины сургалтыг сайн малчидтай хамтран 55 иргэн, үйлдвэрлэл дээрх сургалтанд 9 иргэнийг хамруулсан.Ур чадварын шалгалтыг Хайрхан сургалтын төв, аймгийн МСҮТ болон ур чадварын комисстой хамтран 3 удаа зохион байгуулж,59 иргэнийг үнэмлэхжүүлсэн. “Зам барилга уул уурхайн салбарт мэргэжилтэй ажилтан бэлтгэх, үйлдвэрлэл дээрх сургалтын дэд хөтөлбөр”-ийн хүрээнд Төмөр замын замчин мэргэжлээр 100 хүнийг сонгон шалгаруулан 3 сарын сургалтанд хамруулсан. Мөн Вагнер Ази ХХК болон МСТКоллежтой Сургалтын гэрээ байгуулан Улаанбаатар хотод 10 сарын турш сургалтанд хамрагдах 20-30 насны залуучуудыг бүртгэх ажлыг зохион байгуулав.	100.0
	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байр шинээр нээх зорилтын биелэлт	ХААН, Монгол шуудан, Капитал банкаар дамжуулан 341,7 сая төгрөгийн зээлийг 349 иргэнд олгож 480 ажлын байрыг шинээр бий болгон ажилласан. Зээлээр бий болсон ажлын байр нь жижиг худалдаа эрхлэх, мал худалдан авах, модон эдлэл, гар урлалын бүтээгдэхүүний жижиг үйлдвэрлэл эрхлэх, ногоо тарих, авто засварын үйлчилгээ, эсгий эдлэл үйлдвэрлэх зэрэг чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна.Үүнээс 76 иргэнд мал худалдан авахад нь зориулж 41,4 сая төгрөгийн зээл олгов. Олон нийтийн оролцоонд	96.0

			<p>түшиглэн нийгмийн эмзэг бүлгийн өрх иргэдийг төсөл, хөтөлбөр боловсруулах сургалтанд хамруулсан., 45 үүсгэл санаачилгын бүлэгт 17,6 сая төгрөг, 114 өрхийн 520 гишүүдийн үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэх зорилгоор эргэн төлөгдөхгүй нөхцөлтэйгээр 13.5 сая төгрөгийн зээл олгосон.</p>	
6	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд	Ойжуулалт	<p>Жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг сумдын байгаль орчны хяналтын улсын байцаагчдын сургалтаар хайлаас, улиас, сухай, заг, чацаргана, хонхот харгана тарих, арчлах талаар сургалт явуулж, гарын авлага материалаар хангасан.</p> <p>Мөн байгууллагын www.boajg.bblog.mn сайтад мод үржүүлгийн газар байгуулах зөвлөмж болон ойжуулалтын тайлан, статистик мэдээллийг тавьж нийтийн хүртээл болгон ажиллаж байна.</p> <p>БОАЖГ нь өөрийн ойн зурвасын 2 га талбайд 100 ш хайлаас, 500 ш бургас, 400 ш чацаргана, 4000 ш сухай, нийт 5000 ш мод тарьж суулгасан. Ногоон хэрэм хөтөлбөрийг гүйцэтгэх ажлын хүрээнд аймгийн Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтсээс 15 иргэнийг түр ажлын байраар ханган ажиллууллаа. Мөн ойн зурвасын талбайд усалгааны 1000 м хуванцар хоолой, 2 тн, 10 тн-ийн багтаамжтай 2 усан сан байрлуулав. Шинээр 50 м² блок, 21 м² пилонкон хүлэмж барьж, 2000 орчим ширхэг хайлаасны тарьцыг үрээр ургуулаад байна.</p> <p>Засгийн газрын “Ногоон хэрэм” хөтөлбөрийн гүйцэтгэгч аж ахуйн нэгжээр Сайншанд сумын “Багадулаан трейд” ХХК, иргэн Б.Дэлгэрсайхан, Эрдэнэ сумын “Мөрөөдлийн говь” ХХК, Сайхандулаан сумын “Харцага бор” ХХК, Иххэт сумын “Баян хэт” хоршоо, Замын-Үүд сумын “Замын-Үүд”</p>	76.3

			<p>НААҮ ОНӨ ХХК-ийг сонгон шалгаруулж гэрээ байгуулан хяналт тавин ажиллав. Ногоон хэрэмийн гүйцэтгэгч 7 аж ахуйн нэгж 2009 онд 9100 ш мод, сөөгийг 10.0 га талбайд тарьж суулган ургуулаад байна.</p> <p>Байгаль орчин аялал жуулчлалын газраас “Бага дулаан трейд” ХХК, Б.Дэлгэрсайхан нарыг тус бүр 500 ш хайлаасны суулгацаар хангаж, дээрх аж ахуйн нэгж, иргэнийг энэ оны 8-р сарын 23-28-ны өдрүүдэд Өмнөговь аймгийн мод үржүүлгийн газар болон ойжуулалтын ажилтай танилцуулах аялал зохион байгуулан мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэн ажиллалаа.</p>	
		<p>Ус цаг уур. Орчны шинжилгээ, мэдээллийн үйлчилгээ</p>	<p>Ус цаг уур, орчны шинжилгээний улсын сүлжээний нэгж бүрт ашиглаж байгаа багаж хэмжих хэрэгслэлийг шалгаж баталгаажуулах график гарган мөрдөж, өртөө, харуулд шалган туслах ажлын явцад хэмжих хэрэгсэл бүрт үзлэг үйлчилгээг давхардсан тоогоор 20 удаа хийж, 10 зөрчил доголдлыг илрүүлэн түүний 90 хувийг нь засч арилгуулсан. Замын-Үүд, Дэлгэрэх, Сайншанд өртөөнд тавигдсан автомат станцуудад үзлэг үйлчилгээг тогтмол хийж хэвийн байна. Цаг уурын шинжилгээний ажлын хөтөлбөрийн дагуу 5 өртөөнд 14600 удаа, 8 харуулд 8060 удаа ажиглалт хийж зохих дэвтэр, хүснэгтийг хөтлөн, боловсруулалтыг бүрэн хийж мэдээллийн сангийн архивд шилжүүлээд байна. Шаардлагатай хэрэгсэл материалыг бэлтгэн ажиглалтыг хийж, зохих дэвтрүүдийг бүрэн хөтөлж, ажиглалтын материалыг УЦУХүрээлэнгийн ХААЦУ-ын секторт 100 хувь ирцтэй дамжуулсан.</p>	<p>97.5</p>

		<p>Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ</p>	<p align="center">Цөлжилтөөс хамгаалах ажлын хүрээнд:</p> <p>Бэлчээрийг усжуулах ажлын хүрээнд аймгийн хэмжээнд 2009 онд 22 худаг шинээр гаргаж, 81 худаг сэргээн засварлаж бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэв.</p> <p>Нидерландын вант улсын Засгийн газар, Швейцарийн Хөгжлийн Агентлаг, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн буцалтгүй тусламжаар “Цөлжилтийг бууруулах, газрын тогтвортой менежмент” төсөл 2008 оноос 5 жилийн хугацаатай манай аймгийн Алтанширээ, Дэлгэрэх, Өргөн сумдад хэрэгжиж эхлээд байна. Төслийн хүрээнд Алтанширээ, Өргөн сумдад тус бүр 3130 м² талбайд сул элсний нүүлтийг сааруулах механик хаалт хийх, 3 суманд ургамлын гарц, бэлчээрийн даацыг тодорхойлох хяналтын цэг байгуулах, Алтанширээ, Дэлгэрэх суманд тус бүр 2 га талбайд хадлангийн зориулалтаар бэлчээрийг хашаажуулах, Өргөн суманд 1.5 га талбайд ойн зурвас байгуулах, сум бүрт нэг булаг тохижуулах зэрэг ажлуудыг хийж гүйцэтгээд байна.</p> <p>Уул уурхай, нөхөн сэргээлтийн талаар</p> <p>Ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй 59, хайгуулын тусгай зөвшөөрөлтэй 279 ААН үйл ажиллагаа явуулж байна. Эдгээрээс 37 ААН БОНБУ-тэй, 148 ААН БОХТ батлуулан байгаль орчныг нөхөн сэргээх барьцаат дансанд 40.5 сая төгрөг төвлөрүүлээд байна. Айраг, Алтанширээ, Даланжаргалан, Иххэт, Мандах, Өргөн, Сайншанд, Сайхандулаан, Улаанбадрах сумдад нийтдээ 36.8 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийжээ.</p>	<p align="center">100.0</p>
--	--	--	---	-----------------------------

			<p>Дорноговь аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд уул уурхайн олборлолт болон бусад үйл ажиллагаанаас эвдрэлд орж орхигдсон газрын судалгааг Байгаль орчны судалгаа, үнэлгээний “Эко трейд” ХХК-тай 9-р сард хийлээ. Судалгаагаар Хатанбулаг, Өргөн, Алтанширээ, Иххэт, Айраг, Даланжаргалан сумдын нутагт нийт 30 талбарын 19.25 га /192515 м²/ талбайг нарийвчлан тогтоолоо.</p> <p>Алтанширээ сум геологийн анги байрлаж 3 газрын кемфийн орчны 2.5 га, Айраг “Монголрос цветмет” нэгдэл нөхөн сэргээлтийн хөтөлбөр гарган ажиллаж Бужгарын ордод 0.7 га, “Хэрлэн импекс” ХХК Нэргүй толгойд 0.8 га, “Хөх төр” Алтатын ордод 0.6 га, Даланжаргалан суманд “МАК” ХХК 8.2 га, “Пауэрлэнд” ХХК 2.5 га, Чулуун завод 2.0 га, Иххэт суманд Бор-Өндөрийн УБҮ Зүүн цагаан дэл, Хамар усанд 6.0 га, “Жиминг” ХХК, “Эж эрдэнэ” ХХК-иуд Цагаан элгэнд 4.0 га, Улаанбадрах суманд “Коже говь” ХХК 0.4 га, “Коммод” ХХК 0.6 га Өргөн суманд “МРЦ” ХХК-ний Өргөний уулын үйлдвэр 14-р хүдрийн бүсэд 2.5 га талбайд, Эрдэнэ сум “Shegli youtign” компани 3 га, Сайншанд суманд “Доншен газрын тос Монгол” ХХК 8 цооног, “Коже говь” ХХК 1 цооног, Алтанширээ суманд “Монроуд” ХХК 15 цооногт техникийн нөхөн сэргээлт хийж хүлээлгэн өгсөн байна.</p> <p>Өргөн сумын нутаг “ТАРИАЧ-ХҮ” талбайд газрын тосны хайгуул хийж байгаа “Голден сий петролеум” ХХК-ний үйл ажиллагаанд аймгийн МХГ, ГХБХБГ-тай хамтран шалгалт хийж илэрсэн зөрчил дутагдлыг арилгах үүрэг, чиглэл өгч ажиллав.</p> <p>Сайхандулаан суманд хууль бусаар алт олборлож буй иргэдийн үйл ажиллагаанд шалгалт хийж 5 иргэнээс 7</p>
--	--	--	--

			металл хайгч, 9 иргэнээс 5 шороо үлээгч мотор, гар хийцийн пайжуур, хүрз 9ш, жоотуу 4ш, лоом 3ш, осков 4-ийг хурааж, 6 иргэнд торгуулийн арга хэмжээ авч, нийт гар аргаар алт олборлосон 0.4 га талбайг нөхөн сэргээсэн байна.	
7	Эрүүл мэндийн сайд	Мэргэжлийн боловсон хүчний хангалт, чадваржуулах, мэргэшүүлэх ажил, үйлчилгээ	<p>* 2009 онд төв хөдөөгийн эмнэлгүүдэд нийт 18 их эмч, 4 эмнэлгийн мэргэжилтэнг ажлын байраар хангаж ажилласнаар сум, өрхийн эмнэлгүүдийн их эмчийн хангалт 100%, багийн эмчийн хангалт 86.0%, эх баригчийн хангалт 92.3 %, сувилагчийн хангалт 100% байна 4 суманд багийн их эмч ажиллуулж эхэллээ.</p> <p>* ЭМ-н салбарын хүний нөөцийн сургалтын хэрэгцээг тодорхойлон, 2009-2010 оны сургалтын хөтөлбөрийг боловсруулан 2009 онд нийт 749 эмч мэргэжилтнүүдийг сургалтанд хамруулсан нь өнгөрсөн оныхоос 215-аар нэмэгдсэн байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Албан сургалтанд: нийт 49 эмч мэргэжилтэн хамрагдсанаас төвөөс 44.9%, хөдөөнөөс 55.1%, үүнээс дээд мэргэжилтэн 53.1%, дунд мэргэжилтэн 46.9% байна. Эдийн засгийн хямралтай холбоотойгоор төрийн сангийн болон байгууллагын хичээл үйлдвэрлэлийн зардал хасагдсан тул өнгөрсөн оны түвшнээс сургалтанд хамрагдсан хүний тоо 2-оор буурсан байна. • Албан бус сургалтанд: давхардсан тоогоор нийт 494 хүн хамрагдсан нь өнгөрсөн оныхоос 37 хүнээр нэмэгдсэн ба төвөөс 64.6%, хөдөөнөөс 27.7%, өрхөөс 7.7%, үүнээс 62.4% дээд, 37.6 % дунд мэргэжилтэн байна. • Зайны сургалтанд: 206 хүн хамрагдсан нь өнгөрсөн оныхоос 180 хүнээр нэмэгдсэн ба төвөөс 95%, хөдөөнөөс 4.6%, өрхөөс 0.4% үүнээс 48.5% дээд, 51.5% дунд мэргэжилтэн тус тус хамрагдсан байна. 	92.0

		<p>Эх, хүүхдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний үр дүн</p>	<p>* Эхийн эндэгдлийг бууруулах стратеги, ЭМС-ын 2009 оны 149 тоот тушаалыг хэрэгжүүлэх зорилгоор аймгийн Засаг даргын 2009 оны 225 тоот захирамжаар “Эхийн эндэгдлийг бууруулах 2009 оны үйл ажиллагааны төлөвлөгөө”г батлуулж, сумдын Засаг дарга, аймгийн ЭМГ, МХГ-т хүргүүлж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллаж байна.</p> <p>* “Хүүхдийн өвчний цогц менежмент” хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор ХӨЦМ-н шинэчлэгдсэн хөтөлбөрийн сургалтанд орон нутгийн 5 сургагч багшийг бэлтгэн, аймгийн Засаг даргын 377 тоот захирамжаар ХӨЦМ-ийн шинэчилсэн хөтөлбөрийн дотоодын сургалтыг 1 удаа зохион байгуулж, төв, хөдөөгийн 37 эмч, сувилагчийг хамруулж, нийт 810,9 мян.төгрөгийг зарцуулав.</p> <p>* Нэгдсэн эмнэлгүүдийн хүүхдийн эмч нарыг нярайн эмнэл зүйн богино хугацааны, Люксенбургийн Засгийн газрын MNG 4R 2033 төслийн шугамаар 1 их эмчийг нярайн мэргэжил дээшлүүлэх, 1 сувилагчийг нярайн сувилагч бэлтгэх албан сургалтанд хамруулснаар эрт нярайн эмчилгээ, үйлчилгээний чанарт ахиц гарч байна.</p> <p>* Аймгийн ЭМГ-аас сүүлийн 5 жилийн хүүхдийн эндэгдэлд шалтгаан тогтоох судалгааг хийж, цаашид авах арга хэмжээний зөвлөмж боловсруулан сум, өрхийн эмч нарт хүргүүлж хэрэгжилтэнд хяналт тавин ажиллаж байна.</p> <p>* Эх, нялхаст үзүүлэх эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж ажилласнаар эхний 12 сарын байдлаар аймгийн хэмжээнд 1337 эх амаржиж, эхийн эндэгдэлгүй ажиллаж, нялхасын эндэгдэл 8.8 промилээр буураад байна.</p>	<p>90.0</p>
		<p>Урьдчилган сэргийлэх үйлчилгээ</p>	<ul style="list-style-type: none"> • Аймгийн Засаг даргын 2009 оны 170 дугаар захирамжийн дагуу 7 чиглэлээр нарийн мэргэжлийн эмч нарын бүрэлдэхүүнтэй “Явуулын амбулатори” –ийг 14 суманд ажиллуулж, нийт 14719 хүнийг үзлэг, шинжилгээнд хамруулснаас 19.3% нь өвчтэй илэрсэнийг сум, өрхийн эмчийн хяналтад авч, шаардлагатай тохиолдлуудыг 	<p>95.0</p>

			<p>дараагийн шатны эмнэлгүүдэд шилжүүлэв. Энэ арга хэмжээ нь хөдөөгийн иргэдэд хүрсэн үр дүнтэй ажил болсон бөгөөд цаашид жил бүр эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт иргэдийг хамруулах ажлыг зохион байгуулахаар төлөвлөж байна.</p> <ul style="list-style-type: none"> • Мөн 3 сард Замын-Үүд суманд сүрьеэ илрүүлэх урьдчилан сэргийлэх үзлэгийг зохион байгуулж, нийт 954 хүн хамрагдаж, 109 хүнд цэрний шинжилгээ, 26 хүнд флюорографийн шинжилгээ хийж, 3 шинэ өвчлөл илрүүлж хяналтанд авав. • АХБ-ы дэмжлэгтэйгээр хэрэгжиж байгаа “ХДХВ/ДОХ ба хүн худалдахаас сэргийлэх” төсөл, МГБССН-ийн Дорноговь дах салбартай хамтран эрүүл мэндийн тусламжийн явуулын багийг Айраг, Даланжаргалан, Иххэт сумдад зохион байгуулж, 1242 хүнийг урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулж, БЗДХ-ын өвчлөл 23, халдварт бус өвчлөл 147 илрүүлж, эмчилгээ, зөвөлгөө өгч, сумын эмчийн хяналтад оруулж, 30 хүнийг дараагийн шатлалын эмнэлэгт шилжүүлэв. Мөн үзлэг шинжилгээний явцад эрүүл мэндийн боловсрол олгох мэдээлэл сурталчилгаа хийж, гарын авлага, сурталчилгааны материал тараалаа. 	
8	Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд	Хамран сургалтын хувь /хүрэх түвшний үзүүлэлт/	<p>1. Сургуулийн өмнөх боловсрол</p> <p>2009-2010 оны хичээлийн жилд 22 цэцэрлэгийн 69 бүлэгт 2197 хүүхэд хүмүүжиж, цэцэрлэгийн хамралт 56.5 хувьтай байна. Нийт 559 хүүхэд хувилбар сургалтанд хамрагдан СӨБоловсрол олгогдсон. СӨБ-ын хамран сургалт 62.0 хувьтай байна.</p>	100.0
		Хувилбарт сургалтын хамран сургалт /хүрэх түвшний гүйцэтгэлийн хувь/	<p>Сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж чадахгүй байгаа малчдын болон цэцэрлэгийн гадна байгаа бага насны хүүхдийг Сургуулийн Өмнөх Боловсролд хамруулж, СӨБ-ын үйлчилгээг үзүүлэх зорилгоор явуулын болон нүүдлийн гэр цэцэрлэгийг Даланжаргалан, Дэлгэрэх, Улаанбадрах, Хөвсгөл, Эрдэнэ, Мандах Иххэт 7 сумын нийт 14 багуудад ажиллуулж, 302 хүүхдийг хамруулан СӨБ олгогдсон.</p> <p>Ээлжийн бүлэгт 257, явуулын сургалтанд 115, нүүдлийн гэр цэцэрлэг 187, нийт 559 хүүхэд хувилбар сургалтанд хамрагдаж, СӨБоловсрол олгогдсон. Хувилбар сургалтын хамралт 12.8 хувьтай байгаа нь өмнөх оныхоос 2.8 хувиар</p>	84.3

			нэмэгдсэн үзүүлэлттэй байна.	
		Мэргэжлийн багшийн хангалт /хүрэх түвшний/	Цэцэрлэгийн мэргэжлийн багшийн хангалт 71.4 хувьтай байгаа нь өмнөх онтой харьцуулахад 0,4 хувиар ахисан үзүүлэлт болно.	99.2
		2. Ерөнхий боловсролын сургууль		
		Суурь боловсролын хамран сургалт /хүрэх түвшний/	Суурь боловсролын хамран сургалтын цэвэр жин 2009 онд 85,4% болж өмнөх оноос 4,3%-иар буурсан. Суурь боловсролын хамран сургалтын бохир жин 119,4% болж өмнөх оноос мөн 13,8%-иар буурсан дүнтэй байна.	85.4
		Мэргэжлийн багшийн хангалт	ЕБС-ийн мэргэжлийн багшийн хангалт 98.8%-тай байгаа нь өмнөх жилтэй харьцуулахад 0.3 хувиар ахисан үзүүлэлттэй байна.	99.2
		Бичиг үсгийн боловсролд хамрагдалт / зорилтын биелэлт/	Гэгээрэл төвийн албан бус боловсролын багш нар бичиг үсэггүй иргэдийн судлагааг шинэчлэн гаргаж, тэднийг сургах зуны сургалтуудыг жил бүр зохион байгуулан ажилладаг. Хамран сургалт 99,7 хувьтай байна.	100.0
9	Батлан хамгаалахын сайд	Хууль тогтоомжийг сурталчлах, хэрэгжүүлэх, зохион байгуулах, хэрэгжилтэнд хяналт тавих	Батлан хамгаалах тухай хууль тогтоомж сурталчлах ажлыг ээлжит цэрэг татлагын урьдчилсан үзлэг болон түүхт ой, тэмдэглэлт өдрүүдтэй хамтатган зохион байгуулж аймгийн радио, телевиз, өдөр тутмын хэвлэлээр мэдээлэл бэлтгэж олон нийтийн хүртээл болгон ажилласан.	95.0
		Цэргийн үүрэгтний бүртгэл хөтлөх, сургаж бэлтгэх, сургалтын материаллаг баазыг бэхжүүлэх, цэрэг татлага зохион байгуулах, цэргийн албыг дүйцүүлэн хааж буй иргэдэд сургалт явуулах	Цэргийн шинэчилсэн тоо бүртгэлийг аймгийн Засаг даргын 2008 оны 641 дугаар захирамжийн дагуу 14 сумын хэмжээнд зохион байгуулж холбогдолтой мэдээ тайланг гаргаж БХЯ, ЗХЖШ-т цаг тухайд нь хүргүүлсэн. Аймгийн Засаг даргын 2009 оны 104 дугаар захирамж, Тамгын газрын даргын 2009 оны 33, 77 дугаар тушаалуудыг үндэслэн 2009 оны 1, 2 дугаар ээлжийн цэрэг татлагыг зохион байгуулж явууллаа.Засгийн газрын 2008 оны 49 дүгээр тогтоолыг үндэслэж цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаахаар санал өгсөн иргэдээс сонгон шалгаруулж Цэргийн	98.0

			<p>албыг биеэр дүйцүүлэн хаалгах тухай аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2009 оны 92 дугаар тогтоол гаргуулж Даланжаргалан, Мандах, Сайхандулаан, Хатанбулаг, сумдаас нийт 12 иргэнийг тус албанд шинээр татав. Засгийн газрын 2009 оны 56 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах иргэний төлөх төлбөрийн суурь хэмжээг 2300000 төгрөг байхаар тогтоосны дагуу 2009 онд нийт 65 иргэнээс 12.246.000 төгрөгийг аймгийн төв төрийн сангийн 060051026 тоот дансанд төвлөрүүлсэн.</p>	
		<p>Дайчилгааны төлөвлөгөөг тодотгож баталгаажуулах, даалгаваржуулах, дайчилгааны бэлтгэл нөөцийн сургалтыг зохион байгуулах</p>	<p>Монгол Улсын Засгийн газрын 2004 оны 63 дугаар тогтоолоор батлагдсан “ Аймаг нийслэлийн дайчилгааны төлөвлөгөө”-г тодотгох ажлыг 2008 оны суурь үзүүлэлтүүдэд үндэслэн санхүү төсөв, хүн ам нийгмийн халамж, боловсрол соёл, эрүүл мэнд, хөдөө аж ахуй, дэд бүтцийн салбаруудын болон хүн амын өргөн хэрэглээний бараа, аймгийн төвийг нүүлгэн шилжүүлэх, тээвэрлэх материал хэрэгсэл, шаардагдах зардлын тооцоо судалгааг 2009 онд хийж гүйцэтгэсэн. Аймгийн дайчилгааны төлөвлөгөөг үндэслэн 14 сумдын дайчилгааны төлөвлөгөөнд сумдын Засаг дарга, ЗДТГ-ын дарга нартай хамтран 2009 оны 2 дугаар улиралд тодотгол хийж даалгаваржуулсан. Батлан хамгаалахын сайд, Төсвийн ерөнхийлөн захирагчийн хооронд байгуулсан гэрээ, ЗХЖШ-ын даргын 2009 оны ... дугаар тушаалын дагуу Дайчилгааны бэлтгэл нөөцийн офицерууд, I зэргийн бэлтгэл үүрэгтэнтэй явуулах сургалтыг олгогдсон зардалд багтаан, 2009 оны 11 дүгээр сарын 20-ноос 11 дүгээр сарын 30-ны өдрүүдэд Зүүнбаян дахь Зэвсэгт хүчний 336 дугаар ангийн байнгын байрлал, сургалтын төвд зохион байгуулалтын зохих түвшинд явуулсан.</p>	<p>95.0</p>

	Хэрэгжилтийн дундаж хувь	93.3
	Үнэлгээний оноо	4.66

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР